

B.Well

Caring for everyone

WF-4000

Хүргэх шаардлагагүй инфра улаан туяаны дулаан хэмжигч

MN Ашиглах заавар	B.WELL SWISS CONTROLLED
--------------------------	--------------------------------

1. УДИРТГАЛ

Хүрэлгүй хэмжих инфра улаан туяаны WF-4000 дулаан хэмжигчийг сонгосон танд талархал илэрхийлье. Эмнэлгийн цахилгаан инфра улаан туяаны WF-4000 дулаан хэмжигч нь бүх насны хүний бие, хүрээлэн буй орчин ба эд зүйлсийн хэмийг хүрэлгүй хэмжих зориулалттай.
Ашиглах хүрээ: инфра улаан туяаны дулаан хэмжигч нь хувийн хэрэглээнд зориулагдсан, түүнчлэн эрүүл мэндийн байгууллага ба гэрэээр эрүүл мэндийн тусламж үзүүлэх албанд ашиглагдаж болно. Хүний бие эсвэл эд зүйлийн гадаргуугийн цацруулдаг инфра улаан туяаны цацарлыг дулааны хэмийн утга болгож хэмжих явдалд дулаан хэмжигчийн ажиллагааны зарчим үндэслэдэг. Хүргэхгүй хэмжинэ- хүргэх хэрэггүй дулаан хэмжигчийн давтагдашгүй чанар!

Дулаан хэмжигч нь дараах дагуу талуудтай:

- Дотор 3 дулаан хэмжигч** – хүний биеийн хэмийг хэмжих, орчны агаарын хэмийг хэмжих ба эд зүйлсийн гадаргуун хэмийг хэмжинэ.
- Түргэн хэмжилт** Инфра улаан туяаны технологийн ачаар хэрэглэгчид биеийн дулааны хэмийг шууд ба зөв мэдэж чадна.
- Санах ойд 32 хадгалагдсан үзүүлэлтийг харж болно.** Сүүлийн 32 дулааны хэмжилтийг үр дүнг ой санамжаас харах боломжтой.
- Унтраах боломжтой дуу чимээний дохио**
- Хүний биеийн хэмийн хэмжилтийн** горимд өндөр хэмийн тухай дохио өгнө.
- °C/°F солих боломж** (Цельсийн/Фаренгейтийн шатлал)
- Автомат унтраалга** Батарейн хэмнэлттэй зарцуулалтад зориулж багаж түүнийг 10-с дээш секундын турш ашиглахгүй бол автоматаар унтарна.
- Том шингэн болор дэлгэц** Багаж том хэмжээний шингэн болор дэлгэцтэй, үр дүн хялбар тооцогдоно.
- Ариун цэврийн дүрмийн баримтлал** Хүргэхгүй эрүүл мэндийн дулаан хэмжигч нь эрүүл ахуйн дүрэм журмын баримтлалын шаардлагатай нийцэж дулааны хэм тодорхойлох боломжийг хангадаг. Дулаан хэмжигчийг хүний духанд зайнаас ойртуулж дулааныг хэмжинэ үү.
- Ашиглахад хялбар ба энгийн** Үр ашгитай загварын ачаар дулаан хэмжигчийг ашиглахад хялбар ба энгийн байдаг.

2. ӨНДӨР ХЭМ

Өндөр хэм- энэ бол шинж тэмдэг, өвчин биш. Энэ бол бидний организм халдвартай тэмцэж байгаа гэсэн үг. Ерөнхийдөө бол энэ бидний организмын хамгаалалтын механизм, биеийн хэм 37°С-с дээш өсөж зүрхний цохилт ба амьслын давтамжийн өсөлтөөр тодорхойлогддог.

Бидний организмын хэвийн хэм хэрвээ түүнийг шулуун гэдсээр хэмжвэл 37,5°С байна, амны дулааны хэм 0,5°С-р бага байдаг (37°С), харин суга хэсгийн хэм ойролцоогоор 1°С-р бага байдаг (36,5°С). Тийм учраас биеийн дулааны хэмийг аль болох үр дүнтэй аргаа хэмжин нь чухал, болж өгвөл биеийн дулааны хэм өндөр байх үед хэмжигчийг байх нь зүйтэй (явах үед, хоолны дараа).

Эрүүл хүний биеийн хэмд дараах хүчин зүйлс нөлөөлдөг:

- Бодисын солилцооны хувийн онцлогүүд
- Нас (няхл ба бага насны хүүхдүүдийн биеийн хэм өндөр байдаг, нас ахих тусам хэм багасдаг; хүүхдүүдийн хувьд хэмийн том хэлбэлзлүүд илүү түргэн ба давтамжтай явагддаг)
- Хувцас
- Хүрээлэн буй орчны дулааны хэм
- Өдрийн цаг (өглөө биеийн хэм бага, өдрийн эцэст өндөр болдог)
- Өмнө нь хийсэн биеийн ачаалал
- Хэмжих арга
- Сарын тэмдгийн мөчлөг
- Дух хэсгийн ялгадас ба хөлс гарсан эсэх (духаар хэмжих үед)

- Дулаан хэмжигдэх тасалгаанд дулаан хэмжигч доод тал нь хагас цагийн турш байх ёстой гэдгийг санаарай, тэгэхгүй бол хэмжилтийн үр дүн нарийн бус гарах магадлалтай.

ХЭМЖИЛТ ХИЙХ АРГА	БИЕИЙН ХЭМИЙН ХЭВИЙН ЗААЛТ
Сугаар	35,2 - 36,7°С
Амаар	35,7 - 37,3°С
Шулуун гэдсээр	36,2 - 37,7°С

3. ЧУХАЛ МЭДЭЭЛЭЛ

Энэхүү багажийг ашиглахын өмнө доор заасан бүх заалтыг мөрдөхийг хичээнгүйлэн хүсье. Доор дурдсан дүрмийг мөрдөхгүй бол эрүүл мэнддээ хор уршиг учруулах эсвэл хэмжилтийн нарийн байдалд нөлөөлөх магадлалтай.

- Хэмжилт хийхийн өмнө өвчтөн болоод дулаан хэмжигч нь өрөөний тогтмол хэмийн нөхцөлд 30-с доошгүй минутын турш байх ёстой.**
- Биеийн дасгал хийх, усанд сэлэх эсвэл агаарт байснаас хойш доод тал нь 30 минутын дараа биеийн хэмийн хэмжилт хийх хэрэгтэй.
- Духны гадаргуу цэвэр ба түүн дээр хөлс, косметик, тос г.м-ийн үлдэгдэл байхгүй байгааж шалгах хэрэгтэй. Шаардлагатай тохиолдолд духаа цэвэрлэж хэмжилтийн өмнө хэдэн минут хүлээн үү.
- Хэмийг удаан хугацааны турш хэмжих шаардлагатай тохиолдолд минут тутам хэмжилт хийх хэрэгтэй. Богино хугацаанд дотор өөрийн хэмийг хэмжих үед хэмжилтийн үр дүнд ялихгүй алдаа гарах боломжтой. Хэмийн удаан хугацааны хэмжилтийн үед тодорхой хугацааны турш гурван хэмжилт хийгээд, дараа нь хамгийн зөв болох дундаж хэмжээг тодорхойлох нь зүйтэй, учир нь хүний биеийн дулааны хэм дулаан хэмжигчид дамжуулагдах нь хэмжилтийн нарийн байдалд нөлөөлөх магадлалтай.
- Энгийн өдрүүдэд эрүүл байдалд хийгдсэн дулааны хэмжилтүүдийн бүртгэл хөтөлгөж хуримтлуулсан мэдээллийг бие халууранс эсэхийг тодорхойлох зорилгоор лавлагаа мэдээлэл болгож ашиглаж болно.
- Хэмжилт хийх мэдрэгчид хуруугаар хүрч болохгүй.
- Хүний биеийн хэм байнга өөрчлөгддөг бөгөөд төрөл бүрийн хүчин зүйлсээ хямаардаг.
- Дулаан хэмжигчийг зөвхөн зориулалтын дагуу ашиглана.
- Дулаан хэмжигчийг ашиглах нь эмчлэгч эмчийг зөвлөгөөг орлохгүй. Хэмжилтийн үр дүнг үндэслэж өөрийн эрүүл мэндийн байдлыг бие даан үнэлж өөрийгөө эмчлэх нь тун аюултай. Эмчийн зааврыг дагана үү.**
- Байгаль орчны аюулгүй байдлын үүднээс ашигласан батарейг үндэсний эсвэл орон нутгийн тогтоолын дагуу устгалд оруулна.

① ХОРИЛГОХ ЗААЛТ:

илрээгүй.


① АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АРГА ХЭМЖЭЭНҮҮД

- Дулаан хэмжигчийг хүүхэд хүрэхгүй газар хадгална, батарей ба багажийн бусад хэсгүүдийг хүүхэд санаандгүй залгасан тохиолдолд нэн даруй эмчид хандана уу.
- Дулаан хэмжигч зөвхөн насанд хүрэгсдийн хяналт дор ашиглагдаж болно.
- Багажийг засварлах ба түүний бүтцэд өөрчлөлт оруулах хориотой.
- Батарей солихоос бусад тохиолдолд багажийг задалж болохгүй.
- Дулаан хэмжигчийн багажид аливаа өөрчлөлт оруулж болохгүй.
- Дулаан хэмжигчийг хэт өндөр хэм хэмжихэд (духаар хэмжих горимд 42°С-с дээш, эд зүйлсийн хэмийг хэмжих горимд 110°С-с дээш), хэт өндөр чийгшилтэй нөхцөлд (85%-с дээш) эсвэл нарны шууд тусгалын үед ашиглаж болохгүй.
- Чийгтэй газар, хэт өндөр хэмд, нарны шууд тусгалтай нөхцөлд багажийг хадгалахаас зайлсхийх хэрэгтэй.
- Багажийн хүчтэй чичрэл ба уналтаас сэргийлнэ үү.
- Батарейг гал руу хаяж болохгүй.
- Дулаан хэмжигчийг зөвхөн заагдсан зориулалтын дагуу ашиглана.
- Хэрвээ өвчтөн дух дээрээ шархат бол биеийн тэр хэсэгт хэмийг хийхгүй байна.
- Хэрвээ өвчтөн биеийн дулааны хэмийг өсгөх нөлөөтэй тодорхой эмийн бэлдмэл хэрэглэж байгаа бол хэмжилт хийж болохгүй.
- Хэмжилт хийх үед дулаан хэмжигчийн ойролцоо гар утас ба холболтгүй утас хэрэглэж болохгүй.
- Хэмжилтийн үр дүнгийн нарийн зөв байдлыг хангахын тулд хүчтэй цахилгаан соронзон сааталтай тасалгаанд хэмжилт хийж болохгүй (жишээлбэл, бичил үелзлийн зуух эсвэл өндөр үелзлэтэй тоног төхөөрөмжийн гаргадаг саатал).
- Энэ термометр нь зөвхөн хувийн төхөөрөмж юм, бусадтай хуваалцахгүй байхыг хүсье. Төхөөрөмжийг бусад хэрэглэгчид ашиглахаасаа өмнө хэрэглэгчийн гарын авлагад заасны дагуу цэвэрлэ.
- Хэмжилт хийх үед батарейны контактад гар хүрч болохгүй.
- Дулаан хэмжигчийг техникийн онцлох үзүүлэлтийн шаардлагын дагуу хадгална уу.
- Өвчтөнтэй контакт үүсгэдэг жижиг хэсгүүдийн материалууд (ABS) ISO 10993-5 ба ISO 10993-10 стандарт шалгурт нийцсэн, хоргүй, харшил өгөхгүй ба цочрол гаргахгүй. Тэд нар орчин үеийн шинжлэх ухааны судалгаа ба технологиид үндэслэсэн Эрүүл мэндийн тоног төхөөрөмжийн удирдамжийн (Medical Device Directive, MDD) шаардлагын дагуу боловсруулагдсан, бусад боломжит харшил илэрсэн тохиолдолд одоогийн байдалаар илрээгүй байна.
- Багаж ашиглах магадлалтай хүн бол өвчтөн. Өвчтөн өөрөө бие дааж хэм хэмжих, мэдээллийг тогтоох, энгийн нөхцөлд батарей солих ба хэрэглэгчийн зааврын дагуу багаж ба дагалдах хэрэгслүүдийн техникийн үйлчилгээг гүйцэтгэж болно.

① ЗӨВЛӨМЖҮҮД


- Дулаан хэмжигчийг зориулалтын дагуу бус ашиглаж болохгүй.
- Төхөөрөмж эсвэл батарей гэмтсэн тохиолдолд багажийг химийн уусгагч, нарны шууд тусгал ба өндөр хэмийн нөлөөнд оруулах хориотой.
- Хэмжилт хийх үед утсаар ярих болохгүй.
- Ажиллагааны магадлашгүй горим эсвэл тохиолдолд үүссэн тохиолдолд түүний тухай төхөөрөмжийн ҮЙЛДВЭРЛЭГЧИД мэдэгдэнэ үү.

4. БАГАЖИЙН УДИРДЛАГЫН ЭЛЕМЕНТҮҮД БА ГЭРЭЛ ДОХИО



Товчлуур	Тодорхойлолт
Горим шилжүүлэгч	Хэмжилтийн горимыг хүний бие ба объектын хооронд шилжүүлж солих
«Меню/Ой санамж» товчлуур	Меню Товчлуурыг удаан дархалдаг меню идэвхжиж тохиргоог хадгална <p>Ой санамж Сүүлийн 32 хэмжилтийн ой санамжийг харах</p>
«Урагшаа» товчлуур	Ой санамжийг харахад: урагшаа хуудас эргүүлнэ <p>Тохиргоонд: үзүүлэлтийг солино эсвэл утгыг өсгөнө</p>
«Буцах» товчлуур	Ой санамжийг харахад: буцаж хуудас эргүүлнэ <p>Тохиргоонд: үзүүлэлтийг солино эсвэл утгыг багасгана</p>

5. ШИНГЭН БОЛОР ДЭЛГЭЦИЙН ТОДОРХОЙЛОЛТ



6. БАТАРЕЙН ТОХИРУУЛГА БА ТҮҮНИЙГ СОЛИХ

Батарей дусааж байгаа тухай урьдчилан сануула:

Дэлгэц дээр батарейн зураг гарч ирэхэд  түүнийг ойрын хугацаанд солих шаардлага гарна. Дэлгэц дээр батарейн зураг анивчх үед  түүнийг дараагийн хэмжилтийн өмнө солих шаардлага гарна.

Батарей солих:

- Батарейн тасалгааны тагийг болгоомжтой хөдөлгөнө (Зураг 3).
- Хуучин батарейг болгоомжтой гаргаж зохих ёсны дагуу устгалд оруулаарай.
- Туйлшралыг харгалзан үзэж шинэ батарей тавина (AA төрлийн 1,5 В шултлэг батарей хоёрыг).
- Батарейн тасалгааны тагийг буцааж байршуулна.

- ТАЙЛБАР:** Бага насны хүүхдийн хүрэхгүй, халууны эх үүсвэрээс хол газар батарейг хадгална. Хэрвээ багажийг удаан хугацааны туршид ашиглахгүй бол батарейг салгаж хадгалахыг зөвлөж байна.

7. ДУЛААН ХЭМЖИЛТ

7.1 Хүний биеийн дулааны хэм хэмжилт:

- Дулаан хэмжигчийг асаахын тулд «Асаах/Хэмжих» товчлуурыг дарна уу.
- Багаж нь эхлээд дэлгэцийн бүх элементүүдийг гаргаж автомат туршилтыг гүйцэтгэж эхлээд дараа нь ажиллахад бэлэн гэдгийг заана (Зураг 4.1).
- Зурагт заасны дагуу багаж нь хүний биеийн «Body temp» горимд байгааг шалгаарай. Шаардлагатай тохиолдолд горимыг солино уу.
- Дулаан хэмжигчийн үрд хэсгийг хүний дух руу чиглүүлнэ. Дулаан хэмжигчийг хүний духнаас 5-8 см зайд барина (Зураг 4.4). «Асаах/Хэмжих» товчлуурыг дараад тавина. Та болгонохон дуут дохиог сонсох ба энэ нь хэмжилт хийгдсэн гэдгийг заана. Хэмжсэн хэмийг хэдхэн минут дараа гаралтүлэн харуулна (Зураг 4.2). Хэрвээ Таны хэм 37,5 °C-с дээш бол Таны хэм хэт өндөр байна гэдгийг заасан гурван дуут дохиог Та сонсох болно.
- Хэмжилтийн дараа хэрвээ дулаан хэмжигч 10 секундын турш ашиглагдахгүй бол тэр OFF (өөрөөр хэлбэл унтарсан) гэж заана (Зураг 4.3), дуут дохио өгөөд автоматаар унтарна.



7.2 Ус, агаар ба эд зүйлсийн гадаргуун хэм хэмжилт:

- Дулаан хэмжигчийг асаахын тулд «Асаах/Хэмжих» товчлуурыг дарна уу.
- Багаж нь эхлээд дэлгэцийн бүх элементүүдийг гаргаж автомат туршилтыг гүйцэтгэж эхлээд дараа нь ажиллахад бэлэн гэдгийг заана (Зураг 5.1).
- Зурагт заасны дагуу багаж нь эд зүйлийн «Object temp» горимд байгааг шалгаарай. Шаардлагатай тохиолдолд горимыг солино уу.
- Дулаан хэмжигчийн үрд хэсгийг орон зай дахь цэг, үс эсвэл эд зүйлсийн гадаргуу руу чиглүүлнэ. Дулаан хэмжигчийг объектоос ойролцоогоор 5-8 см зайд барина (Зураг 5.4). «Асаах/Хэмжих» товчлуурыг дараад тавина. Та болгонохон дуут дохиог сонсох ба энэ нь хэмжилт хийгдсэн гэдгийг заана. Хэмжсэн хэмийг дэлгэц дээр гаралтүлэн харуулна (Зураг 5.2).
- Хэмжилтийн дараа хэрвээ дулаан хэмжигч 10 секундын турш ашиглагдахгүй бол тэр OFF (өөрөөр хэлбэл унтарсан) гэж заана (Зураг 5.3), дуут дохио өгөөд автоматаар унтарна.



8. ТОХИРГООНЫ ҮЙЛЧИЛГЭЭГ АШИГЛАХ:

Тохиргооны меню идэвхжүүлж хэрэглэгчид тодорхой үйлчилгээ сонгож (F1/F2/F3/F4) тэднийг өөрийн хүссэнээр тохируулж болно.

8.1 Хүний бие ба эд зүйл хэмжих горим хооронд солих:

- Дулаан хэмжигчийг асаахын тулд «Асаах/Хэмжих» товчлуурыг дарна уу.
- Багаж нь эхлээд дэлгэцийн бүх элементүүдийг гаргаж автомат туршилтыг гүйцэтгэж эхлээд дараа нь ажиллахад бэлэн гэдгийг заана (Зураг 6.1).
- Дулаан хэмжигч асаалттай байхад хэмжилтийн онцлогийн горим харгдана. Хэрвээ хэмжилтийн горимыг солих шаардлагатай бол «Горим солигч» товчлуурын тусламжтайгаар хүний биеийн горим (Body temp) эсвэл эд зүйлийн горим (Object temp) болгож солино (Зураг 6.2)

8.2 Цельсийн ба Фаренгейтийн шатлалууд хооронд солих: F-1

- Тохиргооны меню идэвхжүүлэхийн тулд «Меню/Ой санамж» товчлуурыг дараад барина.
- Дэлгэц дээр F-1 тохиргоо харгдана.
- Фаренгейт хэмжилтийн шатлалыг сонгохын тулд (дэлгэц дээр F тэмдэг анивчина) «+» дарна, эсвэл Цельсийн хэмжилтийн шатлалыг сонгохын тулд (дэлгэц дээр °C тэмдэг анивчина) «-» дарна (Зураг 7).

8.3 Дуут дохионы тохиргоо: F-2

- F-2 тохиргоог гаргахын тулд F-1 тохиргооны дараа дахиад «Меню/Ой санамж» товчлуурыг дарна уу. Дуут дохио анхнаасаа «OPEN» (өөрөөр хэлбэл асаасан) гэж тогтоогдсон.
- Дуут дохиог асаахын тулд «+» дарна, тэгээд дэлгэц дээр «OPEN» (өөрөөр хэлбэл асаасан) гэж гарна. Дуут дохиог унтраахын тулд «-» дарна, тэгээд дэлгэц дээр «CLOSE» (өөрөөр хэлбэл унтраалттай) гэж гарна (Зураг 8).

8.4 Хэт өндөр хэмийн тухай дохионы тохиргоо: F-3

Хэмжилтийн үр дүн ≥37,5 °C бол дулаан хэмжигч 3 дуут дохио өгнө. Анхнаасаа 37,5 °C хэм тогтоогдсон. Та тохиргоог ашиглаж анхнаас хэмийн утгыг өөрчилж болно:

- F-3 тохиргоог гаргахын тулд F-2 тохиргооны дараа дахиад «Меню/Ой санамж» товчлуурыг дарна уу. Анхнаасаа дулааны хэмийн утга 37,5 °C гэж харгдана. (Зураг 9).
- Хэт өндөр хэмийн утгыг өсгөх эсвэл багасгахын тулд «+» эсвэл «-» дарна уу. Утга 0,1 °C алхмаар өсөж эсвэл багасна.

8.5 Хазайлтын утгыг тогтоо: F-4

Зарим хүмүүс биеийн хэм хэмжих үед хувийн онцлогтой байдаг. Жишээлбэл, хэрвээ духны хэмийн хэмжилт аман аргын хэмийн хэмжилтээс илэж агаатай бол энэ тохиолдолд хазайлтын утга тогтоохыг ашиглаж болно.

- F-4 тохиргоог гаргахын тулд F-3 тохиргооны дараа дахиад «Меню/Ой санамж» товчлуурыг дарна уу. Анхнаасаа хазайлтын утга 0,8 °C байна (Зураг 10).
- Хазайлтын утгыг өсгөх эсвэл багасгахын тулд «+» эсвэл «-» дарна уу. Утга 0,1 °C алхмаар өсөж эсвэл багасна.

8.6 Утгыг хадгалаад гарах (автомат хазайлт):

- Тохиргоог хадгалахын тулд F-4 тохиргооны дараа дахиад «Меню/Ой санамж» товчлуурыг дахиад дарна, дэлгэц дээр «SAVE» (өөрөөр хэлбэл) гэсэн үг гарна.
- Бүх тохиргоонууд хадгална, тэгээд дулаан хэмжигч автоматаар унтарна (Зураг 11).

- ТАЙЛБАР:** Хэрвээ тохиргоо тааруулах ажиллагааны үед дулаан хэмжигч унтарвал шинэ тохиргоо хадгалагдахгүй. Тохиргооны меню идэвхжүүлсний дараа дулаан хэмжигч хэм хэмжих чадахгүй. «Асаах/Хэмжих» товчлуур дарах үед дулаан хэмжигч хэмжилтийн горимд шилжихгүй.

9. САНАХ ХЭМНЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Ой санамжаас татаж харах:

Та сүүлийн 32 хэмжилтийн заалтыг санах ойгоос дуудаж өөрийн эмчдээ эсвэл эмнэлгийн мэргэшсэн ажилтанд үзүүлэх боломжтой.

- Багаж асаалттай байх үед «Меню/Ой санамж» товчлуурыг дарна уу. Ой санамжийн товчлуур нь дэлгэц дээр «M» тэмдгийн хамт сүүлийн хэмжилтийг харуулна.
- Хэмжилтийн сүүлийн 32 үр дүнг сольж харахын тулд «+» эсвэл «-» дарна уу.
- Ой санамжийн үйлчилгээгнээс гарч хэм хэмжих горимд шилжихийн тулд «Асаах/Хэмжих» товчлуурыг дарна уу.

10. АЛДААГ ХАЙХ БА АРИЛГАХ

Шалтгаан	Асуудлын шийдэл
 Хэмжигдсэн хэм дараахаас бага байна: <ol style="list-style-type: none">32,0°С (89,6°F), хэрвээ дулаан хэмжигч хүний биеийн хэмийг хэмжих горимд байгаа бол. 0,0°С (32,0°F), хэрвээ дулаан хэмжигч эд зүйлийн хэмийг хэмжих горимд байгаа бол.	Дулаан хэмжигчийг зөвхөн өгөгдсөн хэмийн хүрээнд ашиглана. <p>Мэдрэгчийн үзүүрийг шаардлагатай тохиолдолд цэвэрлэнэ. Алдааны мэдээ дахин гарч ирсэн тохиолдолд үйлчилгээний төвд хандана уу.</p>
 Хэмжигдсэн хэм доор зааснаас өндөр байна: <ol style="list-style-type: none">42°С (107,6°F), хэрвээ дулаан хэмжигч хүний биеийн хэмийг хэмжих горимд байгаа бол. 110°С (230,0°F), хэрвээ дулаан хэмжигч эд зүйлийн хэмийг хэмжих горимд байгаа бол.	Дулаан хэмжигчийг зөвхөн 16°С-с 40°С хүртэл агаарын хэмтэй өрөөнд ашиглаарай. (60,8°С-с 104°F хүртэл).
 Орчны агаарын хэм нь 16°С ~ 40°С (60,8°F-с 104°F хүртэл) хүрээнд байхгүй байна.	

11. АРЧИЛГАА БА ТЕХНИКИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Хэмжилт хийх мэдрэгч

Спирт шингээсэн хөвөөгөөр болгоомжтой цэвэрлэнэ. Линэ цэвэрлэхийн тулд ус ашиглаж болохгүй.

Халууны шилний гэр

Хуурай, зөөлөн даавуугаар цэвэрлэнэ. Багажийг эвэрлэхэд ус ашиглаж болохгүй.

12. ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ БА ИЖ БҮРДЭЛ

Хэмжээ	93 x 41 x 153 мм
Жин	95 г (батарейгүй)
Хэм хэмжих хүрээ	
Биеийн хэм	32°С-42°С (89,6°F- 107,6°F)
Эд зүйлийн хэм	0°С-110°С (42°F- 230°F)
Хэмжилтийн алдаа	
Биеийн хэм	32°С-42°С: ±0,2°С (89,6°F-107,6°F: ± 6,76 °F)
Эд зүйлийн хэм	0°С-110°С: ±1°С (32°F ~ 230°F: ±8 °F)
Зөвшөөрөл	0,1°С
Ашиглалтын нөхцөл	16°С-с 40°С хүртэл (60,8°F-с 104°F хүртэл) (агаарын харьцангуй чийгшил 85%-с ихгүй)
Хадгалах хэм	25°С-с 55°С хүртэл (13°F-с 131°F хүртэл) (агаарын харьцангуй чийгшил